



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@spa.gov.mn
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024.04.08 № А-1/1492

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу
хүргүүлэх тухай

Тус газраас 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр зарласан ЗТХЯ/20240101116 дугаартай “Зам, тээврийн хөгжлийн сайдын багцад тусгагдсан төсөл, арга хэмжээний авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээ” авах төсөл, арга хэмжээний тендерт оролцохыг сонирхогч этгээдээс тодруулга авах хүсэлт ирүүлсэнтэй холбогдуулан дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

Сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулга	Тодруулгын хариу
Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлагад сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудад Зам, гүүрийн барилгын ажлын хяналтаар ажилласан байх шаардлагад 2023 онд анх удаа шинээр 2.8.3.1 Техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийг авч зам, гүүрийн барилгын хяналтын ажлаар 2023 онд ажилласан тохиолдолд ТШЗ 19.1 дэх заалтыг хангах эсэх.	“Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлагад сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудад Зам, гүүрийн барилгын ажлын хяналтаар ажилласан байх” шаардлага нь дээрх онуудын нийлбэр дүнгээр ижил төстэй ажлын туршлагыг хянан үзнэ. Зам, гүүрийн барилгын хяналтын зөвлөхөөр 2023 онд ажилласан туршлага нь багцын батлагдсан төсөвт өртгийн 30 хувь эсхүл гэрээний үнийн дүнг харгалзахгүйгээр тухайн ажлын хүчин чадал, зам, гүүрийн барилгын хяналтын ажлын нийт хүчин чадлын 30 болон түүнээс дээш хувьтай дүйцэхүйц бол дээрх шаардлагыг хангасанд тооцно.
Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.2 "сүүлийн 2 сар буюу 2024 оны 01, 02-р сарын нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх" гэж заасан. Тендер хүлээн авах эцсийн хугацаанд өөрчлөлт орж 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр болсон нь нийгмийн даатгалын 03 дугаар сарын тайлан илгээсэн байх хуулийн хугацаанаас дариу 7 хоногийн дараа байх тул 2024 оны 02, 03-р сарын нийгмийн даатгалын шимтгэл төлсөн бол	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/199 дугаар тушаалын хавсралт “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын 3, 4 дүгээр бүлэгт заасан нөхцөл үүсэх магадлалыг тооцож тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.2.а-д “... сүүлийн 2 сар буюу 2024 оны 01, 02-р сарын нийгмийн даатгалын шимтгэл төлсөн болохыг “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгана” гэж шаардсан тул 2024 оны 01, 02 дугаар сарын нийгмийн даатгалын

1324023947

<p>Инженер техникийн ажилтнуудын 50-с доошгүй хувь нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх шаардлагыг хангасан гэж үзэх эсэх.</p>	<p>шимтгэл төлөлтийн лавлагааг үнэлгээнд харгалзан үзнэ.</p>
<p>Техникийн саналыг багц тус бүрд илгээх боломжгүй байна. Иймд 2-с дээш багцад санал илгээх үед ажил гүйцэтгэх төлөвлөгөө аргачлал, хүн хүчний мэдээллийг нэгдсэн байдлаар явуулахад ойлгох эсэх.</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27.9-д “Багцтай тендер шалгаруулалтын багц тус бүрд үнэлгээ хийх ба оролцогч хоёр ба түүнээс дээш багцад хамгийн сайн тендер ирүүлсэн бол оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадавхыг магадална” гэж заасны дагуу багц тус бүрд үнэлгээ хийх тул Сангийн сайдын 2023 А/248 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”, төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ийн гарын авлага, хэрэглэгчийн хөтөч цэсээс тухайн тодруулгатай холбоотой мэдээллийг авч зааврын дагуу тендер бэлтгэж илгээнэ үү.</p>

ДАРГА  Ц.БАТЗУЛ



4020020105 СБТ-11261 6529900